# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

/2021 оны жилийн байдлаар /

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр.

| ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Эх үүсвэр | Суурь түвшин /суурь он - 2020 он/ | 2021 он | | Хэрэгжилтийн явц, үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | |
| 2.6.7. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагууд ын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ. | 9 | Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ. | БТ | - | Зохион байгуулсан сургалтын тоо-5<br><br>Нийт төрийн албан хаагчдын 50 хувийг сургалтад хамруулна. | 86411,7 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагадаа 2021 оноос эхлэн хүмүүн бичиг сонин захиалж байгаа. Мөн Төрийн соёрхолт ардын багш Ш.Чоймаа багшийн “нийтийн хэрэгцээний монгол бичгийн цахим сурах бичиг” цуврал 25 хичээлийн цахим сургалтанд хамрагдсанаас гадна дотоод сургалтыг 5 удаа зохион байгуулсан. Мөн Говьсүмбэр аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс “Миний монгол бичиг” аяны хүрээнд зохион байгуулсан уралдаанд амжилттай оролцсон. |
| 2.6.8. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд ын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана. | 11 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана. | БТ | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо -3 Зарцуулсан хөрөнгө -10.0 сая | Гэрээ байгуулан хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо 4-өөс доошгүй | 86411,7 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй. Учир нь төсөв байхгүй. Харин байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд мэдээллийг сар бүр шинэчлэн байршуулдаг. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 4 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээ оруулалтад тогтмол хяналт тавина. | БТ | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь - 87.5<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо – 81<br><br>Хугацаандаа мэдээ оруулалтын хувь – 90<br><br>Тайлан илгээлтийн хувь - 100 | 86411,7 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор аймгийн төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, сангууд болон орон нутгаас татаас авч байгаа хувийн цэцэрлэгүүдийн нийт 77 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд сар бүр тогтмол хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 25 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянан шалгалаа. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт эхний 11 сарын байдлаар 96.7 хувь байна. Өмнөх оны мөн үеэс 9,2 хувиар өсчээ. 2021 оны 3 дугаар улирлын шилэн дансны тайлан илгээлт 100 хувь. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл дутуу буюу зөрүүтэй илэрхийлсэн давхардсан тоогоор 39 байгууллагуудад хугацаатай албан бичиг хүргүүлэн биелэлтийг нь хангуулан ажиллалаа. Тайлант хугацаанд Баянтал, Шивээговь сумдын Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангуудын цэсийг хаалгуулсан.   |
| | 5 | Төсвийн зарцуулалтын үр ашиг, хяналтыг сайжруулна. | БТ | Хяналт шалгалтын тоо-23<br><br>Илрүүлсэн зөрчлийн дүн-175,787,100 төгрөг | Хяналт шалгалтын тоо-21<br><br>Зөрчлийн дүн өмнөх онтой харьцуулахад 30 хувиар буурсан байна. | 86411,7 | Байгууллагын 2021 онд санхүүгийн хяналт шалгалт-16, дотоод аудит-2 нийт 18 хяналт шалгалт төлөвлөснөөс төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бусаар байгууллагаас ирүүлсэн албан тоот, иргэний өргөдлийг үндэслэн 7 нийт 21 хяналт шалгалт хийсэн. Төлөвлөгөөт 4 хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 50 хувьтай. Шалгалтаар нийт 392125,6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 25976,8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 1913,0 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар улсын ахлах байцаагчийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөхөн төлбөрийн акт тогтоов. Актын барагдуулалт 89.5 хувьтай байна.     |
| 4.1.3. Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, дотоод удирдлагын ERP системийг төрийн байгууллагууда д нэвтрүүлж, тусгай зөвшөөрөл, өргөдөл | 5 | Төрийн цахим мэдээллийн санг өргөтгөн төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлнэ. | БТ | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо -0 | ERP систем нэвтрүүлсэн нутгийн захиргааны байгууллагын тоо -10 | 86411,7 | Төрийн цахим мэдээллийн дотоод удирдлагын ERP системийг бүрэн нэвтрүүлж байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа. |
| | 7 | Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ. | БТ | Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлт ийн хувь - 100 Хугацаа - 15 хоног | Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах системийг хийлгэнэ. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн | 86411,7 | Тайлант хугацаанд 3 байгууллагаас 4 өргөдөл, 3 иргэнээс 3 өргөдөл, нийт 7 өргөдөл ирсэн. Үүнд: аймгийн Онцгой комиссоос Резидент эмч нарын цалингийн зардлыг олгох шаардлагатай эсэхийг шалгуулах, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхээр авсан арга хэмжээний биелэлтийг шалгуулахаар 2 өргөдөл ирүүлсэн, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-аас 2021 оны санхүүгийн үйл ажиллагааг хяналт шалгалт хийлгүүлэхээр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ. | | | | | шийдвэрлэлтийн хувь - 100 Хугацаа - 15 хоног | | өргөдөл ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. 2 иргэнээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой хяналт шалгалт хийлгүүлэх, орон нутгийн орлогын дансанд актын төлбөрийг илүү шилжүүлсэн тул буцаан олгуулахаар ирүүлсэн өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Баянтал сумын ЗДТГазраас иргэдэд олгосон ахуй үйлчилгээний тоног төхөөрөмжийн хэрэгжилт, эргэн төлөлтийг шалгуулахаар ирүүлсэн өргөдлийн дагуу хяналт шалгалтыг хийж байна. |
| 4.2.2. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, төрийн захиргааны байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэн, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулна. | 4 | Төрийн байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоо ISO MNS 9001:2016 стандартыг нэвтрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулна. | БТ | Зохион байгуулсан сургалтын тоо-0 | Зохион байгуулсан сургалтын тоо-1 | 86411,7 | Одоогоор сургалтанд хамрагдаагүй. |
| 4.2.3. Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд | 6 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн албаны хуулийн хүрээнд мэргэшүүлэх сургалтуудад хамруулна. | БТ | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-708 | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-10-аас доошгүй<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-800-аас доошгүй | 86411,7 | Тайлант хугацаанд нийт ажлын байран дахь сургалт-5, мэргэшүүлэх сургалт-3, цахим сургалт-16, танхим-2 нийт 26 сургалтанд 100 хувь хамрагдсан. Мөн Баянтал сумын төсвийн байгууллагын удирдлага болон нягтлан бодогч нарт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд 13 хүн хамрагдсан. |
| | 9 | Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга | БТ | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт -90 хувь, | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь -100 | 86411,7 | Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд төлөвлөгөө гарган дотоод сургалт 5 удаа зохион байгуулж ажилласан. Мөн ажилчдын нийгмийн баталгааг хангах үүднээс |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | | | | ажилчдад дархлааг дэмжиж бассейнд явуулж байгаа. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. |
| 4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 10 | Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | БТ | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-338<br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-100 | Иргэдэд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо-2<br><br>Хамрагдсан иргэд, зорилтод бүлгийн тоо-200<br><br>Төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтын тоо-2<br><br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо-250 | 86411,7 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх төлөвлөгөөний дагуу байгууллагын дотоод сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Мөн хяналт шалгалт хийх бүрдээ ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж байгууллагын шилэн дансанд мэдээлж хэвшсэн. |

Тайлан гаргасан: /Н.Алтанцэцэг/